# Итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан "Эрх зvйн" цахим сургалт зохион байгуулагдлаа

2020 - 9-р сарын 15, Мягмар гариг, 09:19

Аймаг, нийслэл, сум, дvvргийн иргэдийн Толоологчдийн Хурлын сонгуульд ажиллах улсын бvртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад “Эрх зvйн сургалт”-ыг цахимаар хийлээ.

Сургалтад тус аймгийн 97 хэсэгт ажиллах 96 итгэмжлэгдсэн ажилтан хамрагдав.

Сургалтын veэр АНСДИТХ-ын сонгуулийн тухай хууль, сонгогчдын нэрсийн жагсаалт vйлдэх, танилцуулах, хvргvvлэх журам, Итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулах, нууцын баталгааны талаар анхаарах асуудал, Торийн албан хаагчийн ёс зvй, Торийн нууцын хадгалалт, хамгаалалт, мэдээллийн сангийн аюулгvй байдлыг хангах зэрэг сэдвээр мэдээлэл оглоо.











БАТЛАВ:УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.АРМАН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТАНД ЗОРИУЛСАН ЦАХИМ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. СУРГАЛТЫН ЗОРИЛГО

1.1.Аймаг,нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлуудын талаар улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд сургалт зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангахад оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

2.1.Сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 09 цагт цахимаар зохион байгуулна. Сургалтанд Баян-Өлгий аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид, санал авах байрны дэргэд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдана.

ГУРАВ.СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

| Хугацаа | Сэдэв | Хариуцах ажилтан |
|---|---|---|
| 08.30-09.00 | Онлайн холболт, бүртгэл | Бичиг хэрэг, МТА |
| 09.00-09.10 | Сургалтын нээлтийн ажиллагаа. | Хэлтсийн дарга С.Арман |
| 09.10-10.00 | -АНСДИТХ-ын сонгуулийн тухай хууль,<br>-Итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулах, нууцын баталгааны талаар анхаарах асуудал<br>-Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, | Хэлтсийн дарга С.Арман |
| 10.00-10.30 | -Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах талаар | Тагнуулын газрын ажилтан Б.Отгонбаатар |
| 10.30-12.00 | -Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам,<br>-Итгэмжлэгдсэн ажилтны чиг үүрэг, гүйцэтгэх ажил | ИУБТ-ийн дарга Д.Аманбек |

ДӨРӨВ.БУСАД

4.1.Сургалтыг Улсын бүртгэлийн хэлтэс зохион байгуулж, бэлтгэл ажлыг сумын улсын бүртгэгч нар бие даан хариуцана.
4.2.Сургалтаар итгэмжлэгдсэн ажилтнай байгуулсан гэрээ, нууцын баталгааг сумдын улсын бүртгэгч нар хариуцан битүүмжлэн, 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан УБХ-т ирүүлнэ.
4.3.Сургалт зохион байгуулагдах өдөр УБЕГ-ын Хамтын ажиллагаа, сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Өнөртуяа хяналт тавьж ажиллана.
4.4.УБХ-ийн Мэдээллийн технологийн ажилтан Т.Батырхан онлайн холболтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.
4.5.Сумдын улсын бүртгэгч нар сургалтын явцад итгэмжлэгдсэн ажилтнуудыг бүрэн хамруулж, хариуцлагатай ажиллана.
4.6.Сургалтанд хамрагдаж байгаа итгэмжлэгдсэн ажилтнууд онцгой байдлын үед мөрдөж ажиллах дэглэм /амны хаалт, бээлий, хувийн ариун цэвэр, хоорондын зай/-ийг сахиж ажиллана.

-----------оОо--------------